



2019 ОНЫ
1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ТАЙЛАН

ЛэндМН ББСБ ХК нь үйл ажиллагааныхаа цар хүрээг нэмэгдүүлж, 2018 оныг өндөр өсөлттэйгөөр дуусгалаа. 2019 оны 1-р улиралд шинэ гүйцэтгэх удирдлагатайгаар үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн ажиллаж байна.


Тайлант хугацаанд компани итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл, факторингийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлүүдийг нэмж авснаар зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулах бүрэн боломжтой боллоо.

Хувьцаа эзэмшигч харилцагч та бүхэнд 2019 оны 1-р улирлын санхүү, үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайланг хүргэж байна.


1. ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2019 оны эхний улирлын зээлийн голлох үзүүлэлтүүдийг 2018 оны 4-р улиралтай харьцуулахад гэрээт харилцагчдын тоо **28%**, олгосон зээлийн тоо **40%**, олгосон зээлийн үнийн дүн **37%**, зээлийн багц **60%**-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.


ГЭРЭЭТ ХАРИЛЦАГЧИД (ӨССӨН ДҮНГЭЭР)




ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ТОО



ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ҮНИЙН ДҮН (MNT'000)



ЗЭЭЛИЙН БАГЦ (MNT'000)



2. САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

MNT'000	2018 4-р улирал	2019 1-р улирал
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	4,218,150	1,820,379
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	19,199,367	30,619,730
Бусад хөрөнгө	260,085	314,227
Үндсэн хөрөнгө	258,051	299,653
Биет бус хөрөнгө	387,784	376,376
Нийт хөрөнгө	24,323,437	33,430,365
Хаалттай бонд болон бусад зээлийн өглөг	9,849,032	17,605,235
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	-	500,452
Цахим хэтэвч - өглөг	682,695	595,971
Ногдол ашгийн өглөг	-	540,000
Богино хугацаат бусад өглөг	437,336	386,391
Нийт өр төлбөр	10,969,063	19,628,049
Хувьцаан капитал	11,000,000	11,000,000
Хувьцаа гаргахтай холбоотой шууд зардал	(185,793)	(185,793)
Хуримтлагдсан ашиг	2,540,168	2,988,109
Нийт эздийн өмч	13,354,374	13,802,316
Нийт өр төлбөр болон эздийн өмч	24,323,437	33,430,365

3. ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАН

MNT'000	2018 жилийн эцэс	2019 1-р улирал
Шимтгэл болон түүнтэй адилтгах орлого	7,143,319	3,469,784
Хүүгийн зардал	(511,934)	(572,618)
Цэвэр орлого	6,631,385	2,897,166
Зээлийн болзошгүй эрсдэлийн зардал	(408,524)	(269,025)
Үйл ажилгааны цэвэр орлого	6,222,860	2,628,141
Удирдлагын болон ҮА зардал	(2,376,347)	(823,184)
Банк болон бусад системийн шимтгэлийн зардал	(981,163)	(412,505)
Нийт зардал	(3,357,510)	(1,235,689)
Татварын өмнөх ашиг	2,865,350	1,392,452
Татварын зардал	(305,037)	(144,511)
Цэвэр ашиг	2,560,313	1,247,941

4. САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕТЭЙ ХАРЬЦУУЛАХАД

	2018 1-р улирал	2019 1-р улирал	ӨСӨЛТ
Гэрээт харилцагчид (өссөн дүнгээр)	40,456	120,583	↗ 198%
Олгосон зээл (MNT'000)	20,347,403	78,868,930	↗ 257%
Олгосон зээлийн тоо	113,655	389,134	↗ 248%
Зээлийн багц (MNT'000)	7,496,251	30,651,778	↗ 309%

2019 ОНЫ 3-Р САРЫН ҮЗҮҮЛЭЛТИЙГ ӨМНӨХ САРТАЙ НЬ ХАРЬЦУУЛАХАД

	2019 2-р сар	2019 3-р сар	ӨСӨЛТ
Гэрээт харилцагчид (өссөн дүнгээр)	112,058	120,583	↗ 8%
Олгосон зээл (MNT'000)	24,541,708	30,416,294	↗ 24%
Олгосон зээлийн тоо	119,574	150,533	↗ 26%
Зээлийн багц (MNT'000)	27,311,331	30,651,778	↗ 12%




5. ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

ЛэндМН ББСБ ХК-ийн хувьцааны үзүүлэлтүүд хөрөнгийн биржийн борлуулагдаж байгаа хувьцаанууд дунд тэргүүлэх үзүүлэлттэй хэвээр байна.

2019 оны 1-р сарын 6-ны өдрөөс эхлэн МХБ-ийн I-р самбарт шилжин ангилал ахилаа.


ЛэндМН-ийн ТУЗ-ийн хурлаар баталсан шийдвэрийн дагуу хувьцаа эзэмшигчдэд 2018 оны цэвэр ашгийн 31.85% буюу 800 сая төгрөгийн ногдол ашгийг тараах шийдвэр гарсан. Тус шийдвэрийн дагуу 2019 оны 3-р сарын 27-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн бүртгэлтэй дансанд шилжүүлээ.

НЭГ ӨДРИЙН АРИЛЖААНЫ ДУНДАЖ ДҮН (1-Р УЛИРАЛ, 2019)




БИРЖИЙН ӨДРИЙН НИЙТ АРИЛЖСАН ХУВЬЦААНД ЭЗЛЭХ ХУВЬ (1-Р УЛИРАЛ, 2019)

НИЙТ АРИЛЖААЛАГДСАН ШИРХЭГ



НИЙТ АРИЛЖААЛАГДСАН ҮНИЙН ДҮН



6. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД, ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

ЛэндМН ББСБ нь

ЛэндМН-ий хэрэглэгч харилцагчдаа урамшуулах зорилгоор хэд хэдэн урамшууллын үйл ажиллагааг зохион байгуулж, шинэ үйлчилгээнүүдийг нэвтрүүлээд байна.



Лэнд хэтэвч хэрэглэгч сар шинийн өдрүүдэд өдөр бүр Лэнд хэтэвчний Азын авдар дахь бэлгүүдээс сонгон азаа үзэх, ЛэндМН-тэй хамтран ажиллагч байгууллагуудын 80%-ийн хямдралын купоноор хэрэглэгчиддээ бэлэг барьлаа.



Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан үнэнч хэрэглэгчиддээ зөвхөн эмэгтэйчүүдийн баярт зориулсан хамгийн шилдэг 30-н төрлийн бэлгийн сонголтуудыг купоны урамшууллаар хэрэглэгчиддээ зориулан хүргэлээ.

Лэнд хэтэвчээр дамжуулан хэрэглэгчдэд хүргэх бүтээгдэхүүн үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд Анд Системс ХХК-тай хамтран хэрэглэгчдийн өдөр тутам ашигладаг бүтээгдэхүүн үйлчилгээг мини аппликейшн хэлбэрээр Лэнд хэтэвчийн нэмэлт үйлчилгээ болгон орууллаа.



Ингэснээр хэрэглэгчид Хэтэвчнээсээ шууд киноны тасалбар худалдан авах, өдрийн хоол захиалах, эрүүл шинэхэн хүнсийг онлайнар захиалж худалдан авч байна.

Эдгээр үйлчилгээнүүдийг нэгтгэсэн бусдаас ялгарах гол онцлог нь онлайн худалдан авалт төлбөр төлөлтийг хялбараар хийх боломжийг бүрдүүлээд байна.

ЛэндМН ББСБ ХК нь 2019 оны ээлжит Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулж, Компанийн 2018 оны үйл ажиллагааг тайлагнаж, ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг томилох зэрэг асуудлуудыг хэлэлцэж, шийдвэр гаргав.

Мөн тус хурлаар компанийн 2019 онд хийхээр төлөвлөж байгаа ажлуудаас товч танилцуулав.



7. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ХЭ-ийн хурлаар шинээр томилогдсон ТУЗ маань 2019 оны 4 дүгээр сарын 24-ны өдөр болох ээлжит хурлаараа Компанийн шинэ бүтцийг батлах эсэх асуудал, ТУЗ-ийн дарга, нарийн бичиг, хороодын бүрэлдэхүүнүүдийг томилох зэрэг асуудлуудыг хэлэлцэхээр төлөвлөж байна.

ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮД:



Мэтью Вэлч

Олон улсын санхүүч
AND FSG
Гүйцэтгэх захирал



О.Болдбаатар

Санхүүч, Аудитор, ОУ-ын МНБ
Анд Глобал ХХК
Гүйцэтгэх захирал



Н.Цэвэгмид

Эдийн засагч
Мирэ Эссет ХХК
Гүйцэтгэх захирал



Б.Дэлгэржаргал

Санхүүч
Анд Системс ХХК
Гүйцэтгэх захирал



С.Энх-Амгалан

Олон улсын харилцаа
Петровис ойл ХХК
Гүйцэтгэх захирал



В.Баярсайхан

Програм хангамжийн инженер
АНД Глобал,
Үйл ажиллагаа хариуцсан захирал

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД:



С.Боргил

Эдийн засагч, санхүүч
Сэргэлт Консалтинг Групп
Гүйцэтгэх захирал



Ж.Жаргалсүрэн

Санхүүч, Аудитор
Далайван аудит ХХК
Гүйцэтгэх захирал



Ч.Номин

Эдийн засагч
Монгол телевиз ХХК
Гүйцэтгэх захирал